



АХМАДЫН ХОТХОН-1 ӨНӨААТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/2

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 29 дүгээр зүйлийн 29.1, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын 2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2018 оны “Зорилт батлах тухай” А/259 дүгээр захирамжийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь

1.Тус хотхоны 901,902 дугаар байрны дээврийн засварын ажлыг гүйцэтгэх “Ногоон дом” ХХКомпанитай байгуулсан ХА/01 дугаартай “Дээврийн ажил гүйцэтгэх гэрээ”-ний 3.2 дахь заалтын дагуу гэрээний үнийн дүнгийн 60 хувь болох 13.020,000 /Арван гурван сая хорин мянган / төгрөгийг зохих зардлаас гаргахыг нягтлан бодогч /С.Баяржаргал/-д зөвшөөрсүгэй.

2. “Дээврийн ажил гүйцэтгэх гэрээ”-ний дагуу хөрөнгө гаргасантай холбогдуулан засварын ажлыг эхлүүлэх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг дулааны инженер /Г.Чулуунбаатар/-т үүрэг болгосугай.

ДАРГА



ЦОТГОНБАТ